



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 85,507,933.00 (наян таван сая таван зуун долоон мянга есөн зуун гучин гурван) төгрөгийн балансын үнэ, 77,685,020.00 (далан долоон сая зургаан зуун наян таван мянга хорин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Иргэний нисэхийн ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь Нисэх буудалд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Говь-Алтай аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашинны улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000403

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн
88 дугаар тогтоолын хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
НИСЭХ БУУДАЛД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрүйзер-200, 09-49 УБҮ (арал-jtmdu09j6b4035753)	2011.10.16	85,507,933.00	1	85,507,933.00	77,685,020.00	7,822,913.00
	Нийт дүн				85,507,933.00 (наян таван сая таван зуун долоон мянга есөн зуун гучин гурван)	77,685,020.00 (далан долоон сая зургаан зуун наян таван мянга хорин)	7,822,913.00 (долоон сая найман зуун хорин хоёр мянга есөн зуун арван гурван)